

*Э-СОНИН 44*




*Үнэт цаасны зах зээл*

## Үнэт цаасны арилжаа

/2016.08.31 14:05/


Арилжигдсан ширхэг	757,319
Нийт үнийн дүн/Төг/	1,044,505,061
Хэлцлийн тоо	970
Арилжигдсан үнэт цаасны тоо	65
Зах зээлийн үнэлгээ	1,418,459,123,674.00
MSE All индекс	846.91
Тор-20 индекс	11,962.61

## Зах зээлийн үнэлгээ




/Их наяд төгрөг/

## MSE ALL индекс



/Нэгж/

## ТОП-20 индекс



/Нэгж/

## Бүртгэлтэй хувьцаат компани

Нийт	228
Төрийн өмчит	19
Төрийн өмчийн оролцоотой	15
Хувийн өмчийн	194
МХБ-ийн бүртгэлийн I ангилал	7
II ангилал	46
III ангилал	175

## Гишүүн үнэт цаасны компани

Нийт	58
Тусгай зөвшөөрөл /Андаррайтер, Брокер, Дилер	26
Тусгай зөвшөөрөл /Брокер, Дилер/	29

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн
		Тоо ширхэг	Үнийн дүн	Тоо ширхэг	Үнийн дүн	
1	БиДиСек ХК	401 171	157 721 859,11	399 822	167 529 476,10	325 251 335,21
2	Стандарт инвестмент ХХК	65 701	52 326 896,30	19 084	5 742 784,85	58 069 681,15
3	Новел инвестмент ХХК	7 589	4 543 947,00	79 855	32 017 179,63	36 561 126,63
4	Ти Ди Би Капитал ХХК	114 898	29 761 867,80	7 694	4 811 167,30	34 573 035,10
5	Бумбат-Алтай ХХК	8 645	3 653 571,87	25 572	17 248 415,97	20 901 987,84
6	Зэргэд ХХК	3 026	1 343 161,35	60 889	19 192 937,10	20 536 098,45
7	Гендекс ХХК	42 995	17 881 068,50	0	0,00	17 881 068,50
8	Нэйшнл сэкюритис ХХК	345	2 863 500,00	28 868	11 869 466,00	14 732 966,00
9	Ард капитал групп ХХК	41 069	12 692 311,80	4 591	1 633 036,60	14 325 348,40
10	Дэлгэрхангай секюритиз ХХК	535	8 978 100,00	637	3 887 665,00	12 865 765,00
11	Булган брокер ХХК	184	179 285,00	26 070	11 671 273,00	11 850 558,00
12	Азиа Пасифик секьюритис ХХК	1 343	2 732 851,00	24 191	7 064 719,00	9 797 570,00
13	Гаули ХХК	2 513	2 693 770,00	23 388	5 094 400,00	7 788 170,00
14	Голомт секюритиз ХХК	13 952	4 033 950,00	15 005	3 307 648,00	7 341 598,00
15	Монсек ХХК	12 238	4 444 632,10	5 051	2 569 156,00	7 013 788,10
16	Мэргэн санаа ХХК	5	16 000,00	460	5 928 120,00	5 944 120,00
17	Зэт жи би ХХК	13 937	2 660 155,00	127	2 482 700,00	5 142 855,00
18	Санар ХХК	16	200 000,00	665	4 916 835,00	5 116 835,00
19	Дархан брокер ХХК	840	1 034 340,00	4 154	3 648 685,50	4 683 025,50

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

№	Сим-бол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	Дээд	Доод	Нээлт	Хаалт	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /Хувь/
1	APU	АПУ	336 255,00	138 923 171,60	430,00	380,00	430,00	403,55	-32,75	-7,51%
2	GOV	ГОВЬ	8 700,00	72 278 250,00	8 500,00	8 250,00	8 500,00	8 400,00	100,00	1,20%
3	GNR	ГОНИР	2 800,00	476 000,00	170,00	170,00	170,00	170,00	10,00	6,25%
4	ETR	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	1 879,00	156 596,00	85,00	80,00	85,00	84,00	-1,00	-1,18%
5	ADL	АДУУН ЧУЛУУН	813,00	1 155 768,00	1 639,00	1 403,00	1 639,00	1 430,00	-218,00	-13,23%
6	BHL	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	600,00	264 360,00	490,00	429,00	490,00	476,67	51,90	12,22%
7	DLH	СЭЛЭНГЭ ДУЛААНХААН	517,00	310 200,00	600,00	600,00	600,00	600,00	-45,00	-6,98%
8	BAN	БАГАНУУР	384,00	907 070,00	2 650,00	2 300,00	2 650,00	2 300,00	-250,00	-9,80%
9	BVK	УБ-БУК	206,00	72 270,00	470,00	349,00	470,00	349,00	-141,00	-28,78%
10	CHR	УВС ЧАЦАРГАНА	194,00	164 900,00	850,00	850,00	850,00	850,00	0,00	0,00%
11	EER	АРИГ ГАЛ	170,00	377 170,00	2 570,00	2 150,00	2 570,00	2 150,00	0,00	0,00%
12	BEU	БЭРХ УУЛ	116,00	107 320,00	999,00	850,00	999,00	850,00	-74,75	-8,08%
13	ACL	ТЭЭВЭР-АЧЛАЛ	55,00	44 000,00	800,00	800,00	800,00	800,00	80,00	11,11%
14	ALI	СТАНДАРТ НООС	45,00	34 650,00	770,00	770,00	770,00	770,00	-8,00	-1,03%
15	BDL	МОГОЙН ГОЛ	35,00	143 325,00	4 095,00	4 095,00	4 095,00	4 095,00	163,00	4,15%
16	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	28,00	1 096 380,00	43 680,00	38 000,00	43 680,00	41 960,00	3 960,00	10,42%
17	AAR	АВТО ЗАМ	25,00	150 000,00	6 000,00	6 000,00	6 000,00	6 000,00	-375,00	-5,88%
18	ATR	АТАР-ӨРГӨӨ	25,00	1 625 000,00	65 000,00	65 000,00	65 000,00	65 000,00	3 000,00	4,84%
19	AOI	АВТО ИМПЕКС	4,00	8 000,00	2 000,00	2 000,00	2 000,00	2 000,00	-250,00	-11,11%
20	BDS	БИ ДИ СЕК	2,00	3 810,00	2 050,00	1 760,00	2 050,00	1 760,00	-309,00	-14,93%

## Ханш өсөлттэй хувьцаа

2016/08/31 14:05

Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /Төгрөг/	Өөрчлөлт /Хувиар/
		2016-07-29	2016-08-31		
ДАРХАН НЭХИЙ	453,00	23 560,00	23 560,00	5 560,00	30,89%
ГАЗАР СҮЛЖМЭЛ	7,00	53 450,00	53 450,00	12 450,00	30,37%
НАКО ТҮЛШ	430,00	199,00	199,00	29,00	17,06%
ХЭРЛЭН ХИВС	300,00	149,00	149,00	19,00	14,62%
ТЭЭВЭР ДАРХАН	5,00	16 000,00	16 000,00	2 000,00	14,29%
БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	600,00	490,00	476,67	51,90	12,22%
МОННООС	198,00	1 900,00	1 900,00	200,00	11,76%
ТЭЭВЭР-АЧЛАЛ	55,00	800,00	800,00	80,00	11,11%
МОНИНЖБАР	10,00	140,00	140,00	14,00	11,11%
БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	28,00	43 680,00	41 960,00	3 960,00	10,42%
НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	60,00	1 400,00	1 399,00	112,00	8,70%
МЕРЕКС	5 452,00	74,75	70,00	5,00	7,69%
ГОНИР	2 800,00	170,00	170,00	10,00	6,25%
ЖЕНКО ТУР БЮРО	61 254,00	84,50	75,00	3,99	5,62%
АТАР-ӨРГӨӨ	25,00	65 000,00	65 000,00	3 000,00	4,84%
РЕМИКОН	12 512,00	74,70	68,00	3,10	4,78%
УЛААНБААТАР ХИВС	14,00	11 500,00	11 500,00	500,00	4,55%
МОГОЙН ГОЛ	35,00	4 095,00	4 095,00	163,00	4,15%
ГЕРМЕС ЦЕНТР	14 635,00	145,00	135,00	5,00	3,85%
ГОВЬ	8 700,00	8 500,00	8 400,00	100,00	1,20%

## Ханш бууралттай хувьцаа

2016/08/31 14:05

Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /Төгрөг/	Өөрчлөлт /Хувиар/
		2016-07-29	2016-08-31		
МОНГОЛ САВХИ	1 093,00	768,05	630,00	-273,58	-30,28%
УБ-БУК	206,00	470,00	349,00	-141,00	-28,78%
ЗООС ГОЁЛ	4,00	229 000,00	195 000,00	-70 000,00	-26,42%
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	895,00	770,00	650,00	-140,00	-17,72%
БАЯН-АЛДАР	1 103,00	1 300,00	1 070,00	-230,00	-17,69%
БИ ДИ СЕК	2,00	2 050,00	1 760,00	-309,00	-14,93%
ТАВ	2,00	20 000,00	20 000,00	-3 500,00	-14,89%
МОНГОЛ ШЕВРО	80,00	1 400,00	1 200,00	-200,00	-14,29%
АДУУН ЧУЛУУН	813,00	1 639,00	1 430,00	-218,00	-13,23%
СҮҮ	127 726,00	150,00	132,27	-17,73	-11,82%
ШАРЫН ГОЛ	70,00	3 000,00	2 850,00	-358,00	-11,16%
АВТО ИМПЕКС	4,00	2 000,00	2 000,00	-250,00	-11,11%
ГУТАЛ	553,00	21 260,00	17 000,00	-1 970,00	-10,38%
МОНГОЛ КЕРАМИК	1,00	8 000,00	8 000,00	-890,00	-10,01%
БАГАНУУР	384,00	2 650,00	2 300,00	-250,00	-9,80%



**МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ**

### “СҮҮ” ХК, “АПУ” ХК, БОЛОН “ГОВЬ” ХК САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ТАЙЛАГНАЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Сүү” ХК, “АПУ” ХК, болон “Говь” ХК хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд нээлттэй тайлагналаа.

“Сүү” ХК нь 2016 оны эхний хагас жилд 1,6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 102.5 хувиар өссөн үзүүлэлт юм. Ашигт ажиллагааны хувь нэмэгдэхэд цөцгийтэй тарагны савлагааг сайжруулах, элекстер савлах шугамыг шинэчилж, авто паркыг өргөтгөх зэрэг техник технологийн томоохон хөрөнгө оруулалт бүхий ажлуудыг хийж нэгж бүтээгдэхүүнд ноогдох зардлыг буурлуулсан нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

“Сүү” ХК үйлдвэрлэл үйл ажиллагаагаа нэмэгдүүлэхээс гадна компанийн засаглал, хувьцааны хөрөнгийн зах зээлд чөлөөтэй арилжаалагдах нөхцөлд анхааран хувьцаагаа хуваасан нь хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлснээс гадна компанийн зах зээлийн үнэлгээг 50 орчим хувиар өсгөөд байна.

“АПУ” ХК нь 2016 оны эхний хагас жилд 9.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 67.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Цэвэр ашгийн хэмжээ өсөхөд гадаад валютын ханшийн алдагдал тайлант хугацаанд бага байсан нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

Тус компанийн бодит үнэ цэнэ болон хувьцааг зах зээлд чөлөөтэй арилжаалагдах нөхцөлд анхааран хувьцаагаа хуваасан бөгөөд цаашид валютын зээллэгийг төгрөгт шилжүүлэх, бонд гаргах, түүхий эд материалын форвард хэлцэл хийх зэргээр ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

“Говь” ХК нь 2016 оны эхний хагас жилд 3.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.1 хувиар өссөн байна. Үүнд, гадаад улсууд дахь борлуулалтын хэмжээ нэмэгдсэнээс үүдэлтэй үйлдвэрлэлийн гарц нэмэгдсэн, валютын ханш өссөн зэрэг нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

Тус компани цаашдаа олон улсын тансаг ангиллын бараа бүтээгдэхүүнтэй өрсөлдөхүйц бүтээгдэхүүнийг бий болгохоор олон улсын загвар зохион бүтээгчтэй хамтран ажиллаж байна. Ингэснээр олон улсын тавцанд бүтээгдэхүүний чанар, загвараараа өрсөлдөж, олон улсын тансаг ангиллын бэлэн хувцасны зах зээлд өөрийн байр суурийг баталгаажуулах, цаашид гадаад улс дахь

“Говь” нэрийн барааны дэлгүүрийн тоогоо нэмэгдүүлэх, дэлхийд ноолууран пальтоны үйлдвэрлэлээр тэргүүлэгч болох стратеги зорилт тавин ажиллаж байна.

### “МАХИМПЕКС” ХК САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ТАЙЛАГНАЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Мах импекс” ХК 2016 оны эхний хагас жилийн санхүү болон үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн биржийн хурлын танхимд олон нийтэд нээлттэй тайлагналаа.

Тус компани 2015 оноос эхлэн техник технологийн шинэчлэлтийг эхлүүлж, 2016 онд хиам болон лаазалсан бүтээгдэхүүний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн бүрэн шинэчлэлтийг хийж чадсан. Мөн Европ стандартын савлагааны технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлсэн нь Монголдоо төдийгүй Ази тивдээ анхдагч болж байна. Одоо ISO 22000 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд ингэснээр бүтээгдэхүүнээ экспортлох улсын тоо болон бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх боломжтой болох юм.

“Мах импекс” ХК 2016 онд IFFA буюу Олон улсын махны салбарын хамгийн том үзэсгэлэнгээс Монгол Улсаас анх удаа өөрсдийн “Нүүдэл” болон “Дээжис” нэрийн бүтээгдэхүүнүүдээрээ алт, мөнгөн медаль хүртсэн нь тус компанийн бүтээгдэхүүнүүд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөний тод илрэл болж байна.

### БУТАНЫ ВАНТ УЛСЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ ТАНИЛЦЛАА

Бутаны вант улсын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал тэргүүтэй төлөөлөгчид 2016 оны 8 дугаар сарын 29-30 өдрүүдэд Монголын хөрөнгийн бирж дээр сургалт, семинарт хамрагдаж байна. Энэхүү сургалт, семинарын хүрээнд Бутаны хөрөнгийн биржийн төлөөлөгчид Монголын үнэт цаасны зах зээл, Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагаа, дэд бүтцийн талаар туршлага судалснаас гадна Монголын хөрөнгийн биржийн 5296 дахь арилжааг нээж, цан цохих үйл ажиллагаанд оролцлоо.

### М.БОЛОР: БИДНИЙГ УЯАД БАЙДАГ ГАНЦ ЗҮЙЛ НЬ ЗЭЭЛЖИХ ЭРХ

#### НЭЭЛТТЭЙ ЗАХ ЗЭЭЛ ЗӨВХӨН ИТГЭЛ ДЭЭР Л СУУРИЛДАГ

-Хаалттай зах зээл гэж юуг хэлэх вэ гэвэл нэг өрөөнд хоёр хүн уулздаг. Ингэхээр аль нэг нь давуу талтай болчихдог. Тухайлбал, би тодорхой хэмжээний хөрөнгөтэй байгаад мөнгөө арилжааны банкинд хадгалууллаа гэхэд хүссэн хэмжээгээрээ хадгаламжийн хүүг тогтоох давуу эрх үүснэ.

Тийм ч учраас бид сүүлийн 25 жил хадгаламжийн хүүг ерөөсөө буулгаж чадаагүй. Хаалттай зах зээл дээр банк мөнгө авчихвал түүгээрээ зээл олгоно. Ингэхдээ зээл авч байгаа хүнийхээ дэргэд банк давуу талтай болчихож байгаа юм. Хаалттай зах зээлийн дутагдалтай тал нь тэр. Гадны зах зээлтэй харьцуулахад манай хадгаламжийн дундаж хүү 13 хувьтай байгаа. Өнөөдөр зээлийн хүү 23 хувь хүртэл байгаа. Мэдээж, өндөр сонсогдоно.

Гэхдээ цаашдын бизнес нь илүү өгөөжтэй бөгөөд мөнгөжиж чадах юм бол их, бага гэдэг яриа байх ёсгүй.

Тэгвэл нээлттэй зах зээл дээр бүх хөрөнгө оруулагчаа нэг сагсанд хийчихэж байна. Тиймээс Хөрөнгийн бирж дээр хүн болгон “Би нэг хувьцаа эсвэл бондоо тэдэн төгрөгөөр зарна, авна” гэсэн саналаа ил хэлдэг. Тэгэхээр янз бүрийн санал орж ирнэ. Хөрөнгийн бирж юу хийх вэ гэвэл хоёр саналыг хооронд нь зуучилж өгнө. Өөрөөр хэлбэл, хэн нэг нь нөгөөдөө нөлөөлж чадахгүй. Хаалттай зах зээл дээр дундаж хүү тогтох боломжгүй бол нээлттэй зах зээл дээр дундаж хүү тогтох ганц боломж нь бүрддэг. Тиймээс ч хөрөнгийн зах XVII зуунаас хойш хөгжсөөр яваа юм. Манай улсын хувьд одоогоор нийт санхүүжилтийн долоон хувь нь хөрөнгийн зах руу, 93 хувь нь арилжааны банкууд руу ордог. Харин гадны зах зээл дээр 50:50 хувьтай байдаг юм билээ. Ингэснээрээ бие биенийхээ эрсдэлийг тэнцвэржүүлдэг. Бүгдээрээ нээлттэй байж болохгүй шүү дээ. Эрсдэлтэй. Гэхдээ нээлттэй зах зээл зөвхөн итгэл дээр л суурилдаг. Эцсийн дүндээ тухайн компанийн үнэ, үйл ажиллагаа ямар байна вэ гэдэг мэдээлэл л үнэн зөв байх хэрэгтэй. Хөрөнгө оруулагч энэхүү мэдээлэл дээр нь үндэслээд хувьцаагаа зарах уу, авах уу, хадгалах уу гэдгээ шийддэг.

Ерөнхийдөө хөрөнгө оруулагчдыг хоёр ангилдаг. Нэг нь арилжааны зарчмаар орж ирдэг. Хоёр дахь хэсэг нь хувь эзэмших эвсэл хувьцаанаас өгөөж хүртэх бодолтойгоор хөрөнгө оруулалт хийдэг. Хаалттай зах зээлээс нээлттэй зах зээлийн давуу тал нь хөрөнгө оруулагч ч бай, мөнгө босгож байгаа нь ч бай аль аль нь дуртай цагтаа гарах боломжтой. Хаалттай зах зээл нь зээл ч бай, хадгаламж ч бай заавал тэр хугацаагаа дуусгаж байж л сална. Зах зээлийн үнэ өсч ч болно, Бууж ч болно. Маш олон янзын боломж байдаг учраас нээлттэй зах зээл оршин тогтнох учиртай.

### ХӨРӨНГИЙН ЗАХ ДЭЭР НЭГ ӨДРИЙН ДОТОР 15 ХУВИЙН АШИГ ОЛЖ БОЛНО

-Ер нь аливаа зүйлийг буруу эхэлчихээр хүмүүсийн ойлголт ч гэсэн буруу тогтчихдог шүү дээ. 25 жилийн өмнө бүх компани төрийн өмч байлаа. Ард иргэддээ цэнхэр, ягаан тасалбараар хувьчлах зарчмаар төрийн өмчит компаниудаа хувийн болгосон. Тухайн үед үүнийг сайн ойлгосон хэсэг нь хувьцаагаа сайн цуглуулаад өнөөдөр компанийн эзэд болсон. Ихэнх нь хувьцаагаа үнэ цэнэгүйдүүлж тоогоо ч үгүй, ойлгоо ч үгүй. Манайхан эсрэгээр нь хувьцаат компани биш хувиараа эрхлэх аж ахуйн нэгж байгуулаад хязгаарлагдмал хариуцлагатай компанитай болоод явчихсан шүү дээ. Ямар нэгэн ажил хийгээд түүнийг борлуулж өгөөж хүртэх ёстой л гэдэг ойлголтоос хэтрээгүй. Гэтэл хувьцаа гэдэг ойлголт чинь шал өөр зүйл шүү дээ. Манай АПУ, Сүү зэрэг компаниуд хувьцааны өгөөж гэдэг зүйлийг маш зөвөөр хүлээж авсан. АПУ 3800 хувьцаа эзэмшигчидтэй. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл 3800 гэр бүл АПУ бүтээгдэхүүнийг найдвартай хэрэглэнэ л гэсэн үг. Яагаад гэвэл тэд хувьцаа эзэмшигч бас хэрэглэгч шүү дээ. Бизнес талаасаа нээлттэй компани ашигтай гэдгийг уг нь сайн ойлгомоор байгаа юм.

Бэлэн мөнгө, хадгаламж, хувьцаа, газар, байр, машин гээд манайхан асар их хөрөнгөтэй. Үүгээрээ зээлжих эрх үүсдэг байхгүй юу. Гэхдээ “Энэ бол өгөөж байхгүй. Харин эндээс нь хүү бодож болно” гэх маягаар өгөөжгүй гэснийг нь хасаад явдаг. Тиймээс бид тодорхой хугацаанд өгөөжгүй гэсэн зүйлүүдээ үнэлээд л зээлчих хэрэгтэй. Монгол Улс ерөнхийдөө хоёрхон данстай. Нэг нь арилжааны банкуудад. Нөгөө нь Үнэт цаасны төвлөрсөн тооцооны төвд байгаа. Бид тэгвэл өгөөжгүй гэж үзээд байгаа өмчөө данстай болгочихмоор байгаа юм. Бид өмчөө зөв бүртгэж, байнгын эргэлтэд оруулчихвал өгөөжтэй, мөнгө хурдан эргэлдүүлэх боломжтой. Үүнийг яаж хийх вэ гэвэл бид энд тэндгүй замбараагүй бүртгүүлээд байгаа өмчөө нэг серверт бүртгүүлчихдэг байвал л болно. Ингэвэл хоёр хүн хоорондоо арилжаа эрхлэхэд амархан болно шүү дээ.

Хөрөнгийн бирж нэг өдрийн дотор дээшээ ч, доошоо ч 15 хувийн өсөлт, бууралттай арилжаа хийхийг зөвшөөрдөг. Гэтэл хадгаламжийн хүү жилийн 13 хувь шүү дээ. Тиймээс хөрөнгийн зах дээр нэг өдрийн дотор 15 хувийн ашиг олж болно. Бас алдаж ч болно шүү дээ. Харин нийтээрээ алдана гэсэн ойлголт байхгүй.

### МӨНГӨ ДАМЖИХ ТУСМАА БАЯЛГИЙГ БҮТЭЭДЭГ

-Арилжааны банкуудын блансыг харахад 23 орчим их наяд төгрөгийн бланстай. Хагас жилийн байдлаар үлдэгдэл нь гурав орчим их наяд төгрөг байна билээ. Өөрөөр хэлбэл, бид мөнгөгүй биш мөнгөтэй гэсэн үг. Хамгийн гол нь яаж менежмент хийх вэ гэдэг асуудал байна. Гэхдээ Монгол Улсад мөнгө гурван аргаар нийлүүлэгддэг. Эхнийх нь валют орж ирвэл Монголбанк худалдаж аваад нөөцлөх ёстой. Алт олборлоод Монголбанкинд тушаавал бас л мөнгө нийлүүлэх нэг арга. Гурав дахь нь саяхныг хүртэл янз бүрээр нь хэрэгжүүлж эхэлсэн “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” байдаг. Мэдээж, дийлэнх нь валют гэсэн үг. Ер нь бол гадаадаас 100 ам.доллар орж ирэх юм бол түүний 50-ийг нь Монголбанк худалдаж аваад 50-ийг нь дотоодын зах зээлд нийлүүлнэ гэсэн үг. Гадаадад бонд гаргах нь ийм учиртай. Гэхдээ тэр бонд нь өгөөжтэй, зөв зарцуулалттай байх учиртай. Зарцуулалт нь яавал зөв болдог вэ гэвэл аливаа нэг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ мөнгийг маш олон компани, аж ахуйн нэгжид дамжуулах л ёстой. Мөнгө дамжих тусмаа баялгийг бүтээдэг шүү дээ. Эс бөгөөс хоёр хүн хэрэглэчихээд буцаагаад хүүгээ төлчихдөг бизнес бол тэр чинь өгөөж өгөхгүй. Хүн болгонд л нийлүүлэгдэж байж, нөгөө мөнгөн дүн маань явж буй хурд нь өндөр байх тусам өгөөжтэй.



Бид мөнгөний эргэлт гэдэг зүйлээ валют дээр суурилсан биш баялаг дээр суурилсан, мөнгөний хурд нь яаж байна вэ гэдэг бодлоготой болгох цаг болсон.

### **ХАМГИЙН САЙН НӨХЦӨЛ, БОЛОМЖТОЙ САНХҮҮЖИЛТ ХӨРӨНГИЙН ЗАХ ДЭЭР БАЙГАА**

-Манай компаниуд нэг салбар цэцэглэж байна гэвэл бүгдээрээ тийшээ гүйгээд орчихдог. Тоног төхөөрөмж, ажиллах хүч гээд бүгдээрээ л дор бүрнээ зардал гаргадаг. Ингэхээр цэцэглэж байсан тухайн салбарыг бүгдээрээ түлхээд унагаачихна гэсэн үг. Манай ноолуурын зах зээл их харамсалтай санагддаг. Монгол Улс дэлхийн зах зээлийн 35 хувийг ноолуураар хангадаг шүү дээ.

Гэтэл дотоодын зах зээл дээр энэ чиглэлийн 300 компани байгаа учраас үр ашигтай ажиллах боломжгүй юм. Тэд бие биетэйгээ өрсөлдөж, ханшаа унагаачихаж байна. Гэтэл 300 мундаг технологич байна уу гэвэл асуудалтай. Харин 300 захирал, 300 нягтлан бодогч, 300 банкны зээл байгаа гэж бодохоор бид аливаа нэг бизнесийг улам л үнэтэй болгоод байна гэсэн үг. Яагаад бид үндэсний хэмжээний таван компанитай байж болохгүй гэж. Магадгүй, тэнд л хамгийн шилдэг, сайнууд нь ажилладаг, тоног төхөөрөмжөө 100 хувь ашигладаг байг. Гэтэл 300 үйлдвэр өндөр үнэтэй тоног төхөөрөмж авна. Тэгээд дунджаар 20 хувийг нь л ашигладаг юм билээ. Тэр чигээрээ маш их зардал гаргачихсан хэр нь гүйцэд ашиглагдахгүй байгаа юм. Тиймээс аливаа нэг бизнесийг хийхдээ яг адилхан 300 үйлдвэр байгуулах биш түүнээсээ шилдэг таван компанийг нь л ажиллуулах хэрэгтэй. Нөгөө 295 нөхөр маань хөрөнгө оруулагч байж болно шүү дээ. Хувьцааг нь эзэмшээд, өгөөж хүртээд сууж болно.

Биднийг уяад байдаг ганц зүйл нь зээлжих эрх. Засаг төрөөс яадаг вэ гэвэл, Сангийн яамнаас хямд эх үүсвэртэй зээл олгоно гээд л өөрсдөө шинээр нэг компани гаргаж ирээд зээл өгчихдөг. Ингэхдээ юм хийж буй компаниудаа дэмждэггүй. бид Америк, Хятад шиг биш шүү дээ. Гуравхан сая хүнтэй улс шүү дээ.

Манай компаниуд санхүүжилтийг банкнаас л авдаг гэж ойлгодог. Гэтэл хамгийн сайн нөхцөл, боломжтой санхүүжилт бол хөрөнгийн зах дээр байгаа шүү дээ. Манайхан хөрөнгийн удирдлагын бүхэл бүтэн санхүүгийн албатай баймаар байгаа юм. Гэтэл манайханд санхүүгийн албанд нь нэг нягтлан бодогч яаж зээлээ төлөх вэ, борлуулалт хэр байна вэ гээд л блансаа хараад сууж байдаг.

Түүнээс биш санхүүжилтийг яаж авах вэ, яаж ашиглах вэ, хаана байршуулах вэ гэдэг дээр ямар ч ажил хийдэггүй. Томоохон компаниуд бол бүр өдөр бүхэн үлдэгдэлтэй сууж байдаг. Гэтэл тэр мөнгөө ашиглаж, шөнийн цагаар орлого олдог байх хэрэгтэй шүү дээ. Хөрөнгийн захаас Засгийн газрын үнэт цаасыг аваад ч юм уу ямар нэгэн байдлаар мөнгийг хөдөлгөөнд оруулах бодлого хэрэгтэй. Гэхдээ “Голден сакс” ч юм уу хамгийн мундаг хөрөнгө оруулагч нартай ижилхэн мундаг сайн санхүүчтэй л сууж байх ёстой. Үндсэн бизнесээсээ гадна түүгээрээ ашиг, өгөөж олдог. Яагаад гэвэл, мөнгө харилцах дансандаа л байгаад байвал өсөхгүй шүү дээ. Мөнгөний ид шид хэзээ гардаг вэ гэвэл байнга нэг юм аваад түүнийгээ зараад л байх юм бол баялаг бүтээж байдаг. Сейфэндээ байгаад байвал тэр чинь баялаг биш. Үүнийг л манайхан идэвхтэй анхаарч, тусад нь нэгж байгуулаад мөнгө олж ирдэг бодлоготой болмоор байгаа юм.